



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 267

Улаанбаатар хот

“БиДиСек” ХК-ийн нийтэд санал болгон
гаргах үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9.1, 63.1.10, Компанийн тухай хуулийн 42.4 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “БиДиСек” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан энгийн хувьцааны тоог нийт 6,000,000 /зургаан сая/ ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэн үнэт цаасны бүртгэлд нэмж бүртгэж, тус компанийн нийт хувьцааг нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 17,000,000 /арван долоон сая/ ширхэг байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар /Т.Жамбаажамц/, хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Энэ тогтоолын 1-д заасан нэмж гаргаж буй энгийн хувьцааг компанийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд худалдан авах санал болгох үнийг тус компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс 1,931 /нэг мянга есөн зуун гучин нэг/ төгрөгөөс доошгүй байхаар тогтоосныг зөвшөөрч, тэргүүн ээлжинд худалдан авах саналыг энэхүү тогтоол батлагдсан өдрөөс хойш хуульд заасан журмын дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийг Хороонд тайлагнаж, олон нийтэд мэдээлэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/, “БиДиСек” ХК /Д.Даянбилгүүн/-д тус тус үүрэг болгосугай.

3. “БиДиСек” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлээгүй үлдсэн хувьцааг олон нийтэд санал болгон тогтсон үнийн аргаар анхдагч зах зээлд санал болгох доод үнийг үнэт цаасны танилцуулгад заасны дагуу 2,146 /хоёр мянга нэг зуун дөчин зургаа/ төгрөгөөр тогтоохыг зөвшөөрсүгэй.

4. Нэмж гаргаж буй хувьцааг “БиДиСек” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд худалдан авахыг санал болгох, нийтэд санал болгон арилжаалах ажиллагааны дүнд эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхэд шаардлагатай 11,586,000,000 /арван нэгэн тэрбум таван зуун наян зургаан сая/ төгрөгийн 80-аас доошгүй хувийг төвлөрүүлж чадсан нөхцөлд үнэт цаасыг нийтэд санал болгон худалдах ажиллагааг амжилттай болсонд тооцохоор тогтсугай.

5. “БиДиСек” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжинд худалдан авах эрхийн дагуу хувьцааг худалдан авах хүсэлтийг хүлээн авч дуусгах, нэгдсэн бүртгэл гарган худалдан авсан үнэт цаасны өмчлөх эрхийг шилжүүлэх үнэт цаасны арилжааг олон нийтэд санал болгон гаргах анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/-д, “БиДиСек” ХК /Д.Даянбилгүүн/-д тус тус үүрэг болгосугай.

6. Энэ тогтоолын 4-т заасан мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх боломжтой болсон тохиолдолд “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар дамжуулан хийгдэх уг үнэт цаасны анхдагч зах зээлийн

000277

арилжааг зогсоож, “БиДиСек” ХК-ийн нэмж гаргасан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны тайланг Хороонд ирүүлэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/-д даалгасугай.

7. “БиДиСек” ХК-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдаж дууссаны дараа Хорооноос олгосон зөвшөөрлийн үндсэн дээр хоёрдогч зах зээлийн арилжааг нээхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/-д үүрэг болгосугай.

8. Тус компанийн нэмж үнэт цаас гаргах шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дор дурьдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “БиДиСек” ХК /Д.Даянбилгүүн/-д үүрэг болгосугай.

1/ энэ тогтоолын 1-д заасан 6,000,000 /зургаан сая/ ширхэг хувьцаа гаргах тухай үнэт цаасны танилцуулгад үндэслэн холбогдох журмын дагуу үнэт цаасыг нийтэд сурталчлан, олон нийтийг бодитой мэдээллээр хангаж, хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрхийг ханган, хуулиар хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

2/ үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа хийгдэж дууссанаас хойш холбогдох журмын дагуу ажлын гурван хоногийн дотор үнэт цаасны гүйлгээний талаарх дэлгэрэнгүй тайланг Хороонд ирүүлэх;

3/ үнэт цаасны танилцуулгад заасан хуваарийн дагуу үнэт цаасыг нийтэд санал болгох ажлыг зохион байгуулж, арилжаалагдаагүй үлдсэн хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасуулах эсэх асуудлыг Хороонд тавьж шийдвэрлүүлэх;

4/ үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа явагдсанаас хойш ажлын 10 хоногт багтаан компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай шийдвэрийг холбогдох баримтын хамт Хороонд ирүүлэх;

5/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 505 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

6/ Хорооны 2014 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн 162 дугаар тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ыг үйл ажиллагаандаа чанд баримтлан ажиллаж, түүний хэрэгжилтийн тайланг улирал бүр Хороонд ирүүлэх.

9. Үнэт цаасыг нийтэд санал болгон худалдах ажиллагаа амжилттай болсон тохиолдолд үнэт цаас худалдсаны орлого буюу үнэт цаас гаргагч “БиДиСек” ХК-ийн дансанд байршсан мөнгөн хөрөнгийг энэ тогтоолын 8.4-д заасан баримтыг ирүүлж, Хорооноос зөвшөөрөл өгөх хүртэл хугацаанд тусгаарлахыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

10. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН